

ШУТИС-ИЙН САНХҮҮЖИЛТТЭЙ СУДАЛГААНЫ ТӨСЛИЙН СОНГОН ШАЛГАРУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ УДИРДАМЖ

Зорилго:

ШУТИС-ийн судалгаа, инновацын хөгжилд хувь нэмэр оруулахуйц улс орны нийгэм эдийн засгийн ач холбогдол бүхий судалгааны төслүүдийг сонгон шалгаруулж, 2026 онд санхүүжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулна.

Төслийн төрөл:

ШУТИС-ийн Эрдэм шинжилгээ, технологи хөгжүүлэлтийн алба, Инновац, бизнес түншлэлийн албаас 2026 онд хэрэгжүүлэх (1) **суурь, хэрэглээний судалгаа** /онолын суурь ШУ-ыг хөгжүүлэх/, (2) **технологийн туршилт, зүгшрүүлэлт** /судалгааны үр дүнг үйлдвэрлэл үйлчилгээнд нэвтрүүлэх/-ийн төслийг сонгон шалгаруулж санхүүжүүлнэ.

Тавигдах шаардлага:

Төсөл нь дараах шаардлага, шалгуурыг хангасан байна. Үүнд:

1. Төсөл мэдүүлэх судалгааны багийн удирдагч нь ШУТИС-ийн үндсэн орон тооны (харьяа хүрээлэнгийн судлаачид хамаарна) доктор буюу түүнээс дээш эрдмийн зэрэг цолтой профессор, багш, судлаач байна;
2. Төслийн багийн гишүүдийн тоог хязгаарлахгүй бөгөөд төслийн багт хоёр ба дүүнээс дээш ШУТИС-ийн үндсэн болон гэрээт профессор багш, судлаач, ажилтан, докторын сургалтад хамрагдаж буй нэг оюутныг заавал оролцуулна;
3. Судалгааны төслийг хэрэгжүүлэх хугацаа суурь судалгаа-**15** сар, технологийн туршилт, зүгшрүүлэлтийн төсөл-**24** сараас хэтрэхгүй байна;
4. Судалгааны үр дүнг эзэмших, ашиглахыг ШУТИС-д зөвшөөрсөн байна;
5. “ШУТИС-2030 стратеги төлөвлөгөөний үндсэн зорилгод хүрэх замын зураглал- KPI”-ийн үзүүлэлтүүдэд хувь нэмэр оруулсан байна;

№	Төсөлд тавигдах шаардлага:	
	Суурь, хэрэглээний судалгаа	Технологийн туршилт, зүгшрүүлэлт
1	ШУТИС-ийн тэргүүлэх чиглэлийн хүрээнд онолын суурь хэрэглээний шинжлэх ухааныг хөгжүүлэхэд чиглэсэн бөгөөд шийдвэрлэх асуудал нь тодорхой, оновчтой судалгааны арга замыг сонгосон байх;	Урьд өмнө судлагдсан байх бөгөөд үр дүнгээр "Аж үйлдвэрийн оюуны өмчийн" эрхийн баталгаажилтын гэрчилгээ авсан байх;
2	Олон улсын мэдээллийн сан WoS, Scopus-т бүртгэлтэй мэргэжлийн сэтгүүлд ШУТИС-ийн нэр дээр 1-ээс доошгүй өгүүлэл хэвлүүлэх;	Судалгааны үр дүнг хөгжүүлж үйлдвэрлэл, үйлчилгээнд туршин нэвтрүүлэх;
3	Дэвшүүлж буй судалгааны чиглэлээр ШУТИС-д суралцаж буй 1 докторантыг төсөл хэрэгжих хугацаанд урьдчилсан эсвэл жинхэнэ хамгаалалт хийлгэсэн байх;	Төслөөр хөгжүүлэх бүтээгдэхүүн, үйлчилгээний маркетинг болон бизнес төлөвлөгөөг боловсруулан өрсөлдөх чадвар (зах зээл, үр ашиг, түүхий эд

		материалын талаарх тооцоо, судалгаа)-ийг илэрхийлсэн байх;
4	Судалгааны үр дүнд зохиогчийн эрх, ном сурах бичиг, гарын авлагын аль нэгийг гаргах;	Төслийн судалгаа хөгжүүлэлтийн үе шат 6 сар (бүтээгдэхүүн, үйлчилгээний анхдагч загварыг гаргах), үйлдвэрлэл үйлчилгээнд нэвтрүүлэх үе шат 18 сар төслийн нийт үргэлжлэх хугацаа 24 хүртэлх сар байх;
5	Судалгааны үр дүнг мэргэжлийн чиглэлийн эрдэм шинжилгээний хурал болон ШУТИС-ийн багш, судлаачдын дунд хэлэлцүүлж, түгээн дэлгэрүүлэх;	Төслийг амжилттай хэрэгжүүлэх хүний нөөц, санхүүгийн чадавх (бусад эх үүсвэрээс хамтарсан санхүүжилт авсан бол давуу тал болох)-тай байх;
6	Төслийн санхүүжилтийн нийт дүн: Эргэн төлөгдөхгүй нөхцөлтэй 30 сая хүртэлх төгрөг байна.	Төслийн санхүүжилтийн нийт дүн: 80% нь эргэн төлөгдөх нөхцөлтэй 50 сая хүртэлх төгрөг байна.

Төслийн материал бүрдүүлэх, төсөл ирүүлэх, шалгаруулах хугацаа

- Бүрдүүлэх материал:** Төсөл санаачлагч баг нь доорх материалыг бүрдүүлэн Эрдэм шинжилгээ, технологи, хөгжүүлэлтийн албанд ирүүлнэ.
 - Судалгааны баг нь дэвшүүлэх төслийн саналаа “төсөл мэдүүлэх заавар маягт”-ын дагуу боловсруулж, PDF форматаар research@must.edu.mn цахим хаягаар ирүүлнэ (Материал дутуу ирүүлсэн тохиолдолд сонгон шалгаруулалтад оролцох боломжгүй);
 - Тухайн судалгааны сэдвийн давтагдаагүй байдал, гарах үр дүнгийн төсөөллийн саналыг төслийн удирдагчийн харьяалах бүрэлдэхүүн сургууль, хүрээлэнгийн эрдмийн зөвлөлөөр хэлэлцүүлэн дэмжигдсэн хурлын тэмдэглэл;
- Материал хүлээн авах:** Төслийн материалыг 2025 оны 10 дүгээр сарын 17-ны өдрийн 18:00 цагт хүртэл хүлээн авна.
- Төслийн санал хянах:** Ирүүлсэн төслийн саналын материал бүрэн эсэх, тавьсан шаардлагад нийцэж буй эсэхийг Эрдэм шинжилгээ, технологи, хөгжүүлэлтийн албанд хянан магадалгаа хийж, шаардлага хангасан төслүүдийг шалгаруулалтад урина.
- Сонгон шалгаруулах:** Шаардлагад нийцсэн төслүүдийг 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн дотор ШУТИС-ийн Эрдмийн зөвлөлийн дэргэдэх Эрдэм шинжилгээ, технологийн дэд зөвлөлөөр нээлттэй хэлэлцэж, эцсийн сонгон шалгаруулалтыг зохион байгуулна.

Эрдэмтэн судлаач Та бүхнийг ШУТИС-ийн Захирлын 2022 оны 04-р сарын 29-ний өдрийн А/145 тоот тушаалын хавсралтаар баталсан “[ШУТИС-д Төсөл, гэрээт ажил хэрэгжүүлэх, эрдэм шинжилгээний үйл ажиллагааг санхүүжүүлэх журам](#)”-ийг баримтлан, удирдамжийн дагуу төслийн баримт бичгийг боловсруулан сонгон шалгаруулалтад оролцохыг урьж байна.